



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2019.10.02 № 03/3717

танай _____ -ны № _____ -т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР
Х.ХАШБААТАР ТАНАА

Урьдчилсан мэдүүлэг хянуулах тухай

Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Батмэнхийн Даваасүрэнг сэлгэн ажиллуулж, Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Цогтын Баярбат нь өөр албан тушаалд томилогдож тус тус сул орон тоо гарсан.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;” томилохоор заасны дагуу Бодлого төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн Үйлдвэрлэлийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтнээр Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Даваагийн Баярмааг, Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээчээр Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Алтангэрэлийн Лхамсэргжидийг шилжүүлэн ажиллуулахаар нэр дэвшүүлж байна.

Мөн Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Агааны Энхтувшинг Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээчээр, Бодлого, төлөвлөлтийн газрын Орон сууц, нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбатын Батболдыг тус газрын Салбарын ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээчээр тус тус шилжүүлэн томилохоор нэр дэвшүүлж байна.

Иймд дээрх албан хаагчдын “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг ажлын байрны тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, бусад материалын хамт хавсралтаар хүргүүлж байна.

Холбогдох материалыг хянан, дүгнэлт гаргаж өгөхийг хүсье.

Хавсралт хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСУРЭН

151055550